



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Г Салбар хороо байгуулах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар хорооны дарга:

Зам, тээврийн хөгжлийн дэд сайд

Нарийн бичгийн дарга:

Бодлого, төлөвлөлтийн газрын Стандарт, нормативын хэлтсийн Автомэдрээр, иргэний нисэхийн салбарын стандарт, норматив хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтсийн Төмөр замын тээврийн хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтсийн Авто үйлчилгээ, техникийн хяналтын үзлэгийн хяналт хариуцсан мэргэжилтэн

ИНЕГ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус байнгын зөвлөлийн нарийн бичгийн дарга, НХҮА-ны Хөдөлмөр хамгааллын мэргэжилтэн

“Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн

“Автомэдрэйн үндэсний төв” ТӨҮГ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн

Монголын Тээвэр, Холбоо газрын тосны  
үйлдвэрчний эвлэлийн холбооны зохион  
байгуулагч

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын  
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл  
ахуй хариуцсан мэргэжилтэн,  
Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга

Монголын төмөр замчдын үйлдвэрчний  
эвлэлийн холбооны дарга

Монголын авто замчдын үйлдвэрчний  
эвлэлийн холбооны дарга

Монголын автотээвэрчдийн нэгдсэн  
холбооны сургалтын менежер

Монголын авто замчдын холбооны  
ерөнхийлөгч


2. Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар  
хорооны дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох стандарт,

дүрэм, журмыг мөрдүүлж, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол  
авч хэрэгжүүлэн салбар хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг харьяа  
байгууллагын дарга, захиралд үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016  
оны “Салбар хороо байгуулах тухай” 14 дүгээр тушаал, 2016 оны “Салбар хорооны  
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 117 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд  
тооцсугай.





Зам, тээврийн хөгжлийн  
сайдын 2019 оны 02 сарын  
22 -ны өдрийн 46 дугаар  
тушаалын хавсралт

## ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН САЛБАР ХОРООНЫ ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар хороо /цаашид "салбар хороо" гэнэ/ нь салбарын ажилтны эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

1.2. Салбар хороо нь Олон улсын хөдөлмөрийн конвенци, Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандaa удирдлага болгоно.

1.3. Салбар хороо нь ажлын онцлог шаардлагыг харгалzan хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.

### Хоёр. Салбар хорооны удирдлага, бүрэлдэхүүн, санхүүжилт

2.1. Салбар хорооны бүрэлдэхүүнийг тухайн салбарын асуудал эрхэлсэн сайдын тушаалаар батална. Салбар хорооны дарга нь дэд сайд байна.

2.2. Салбар хорооны нарийн бичгийн даргын үүргийг тухайн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн гүйцэтгэнэ.

2.3. Салбар хороо нь төрийн болон мэргэжлийн холбоо, ажил олгогч, ажилтны төлөөлөл оролцуулсан нийт 12-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.4. Салбар хороо нь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн Үндэсний хорооноос мэргэжил арга зүйн зөвлөгөө авч ажиллана.

2.5. Салбар хорооны үйл ажиллагааны зардлыг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний жил бүрийн төсвийн багцад тусгуулна.

## **Гурав. Салбар хорооны үүрэг**

3.1. Салбар хороо нь дор дурдсан үүрэгтэй байна.

3.1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар салбарт мөрдөх хууль тогтоомжийн төсөлд санал боловсруулах, салбарын дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх;

3.1.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан нөхцлийн талаар судалгаа, шинжилгээ хийлгэх, зөвлөмж гаргах;

3.1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн талаар ажил олгогч, ажилтнуудад мэдээлэл өгөх, сурталчилгаа хийх, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

3.1.4. Салбарын аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга туршлагыг нэвтрүүлэх, зөвлөмж чиглэл өгөх;

3.1.5. Салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой Олон улсын хөдөлмөрийн конвенцид нэгдэн орох асуудлаар судалгаа хийх, санал дүгнэлт гаргах;

3.1.6. Салбар хороо нь үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллаж, тайланг хагас бүтэн жилээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хороонд тайлагнах;

3.1.7. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

## **Дөрөв. Салбар хорооны эрх**

4.1. Салбар хороо нь дор дурдсан эрхтэй байна.

4.1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний талаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл авах;

4.1.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;

4.1.3. Тухайн салбарын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад гарсан үйлдвэрлэлийн ослын шалтгаан нөхцлийг судалж, санал гаргах;

4.1.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар олон улсын байгууллага болон гадаадын байгууллагатай холбоо тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан мэдээлэл, туршлага солилцох;

4.1.5. Тухайн салбарын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам, стандарт, зааварчилгааг санаачлан боловсруулж, хэрэгжүүлэхэд оролцох;

4.1.6. Салбар хороо нь шаардлагатай үед салбарынхаа онцлог, нөхцөл байдалд тохируулан энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдөх;

4.1.7. Хууль тогтоомжид заасан бусад эрх.

**Тав. Салбар хорооны хурал**

5.1. Салбар хорооны хурлыг оролцогч талуудын гишүүдийн 50-иас дээш хувийн ирцтэй хийнэ.

5.2. Салбар хорооны ээлжит хурал улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Хурлыг салбар хорооны дарга зарлаж хуралдуулах бөгөөд шаардлагатай үед ээлжит бус хурлыг нийт гишүүний 50-иас дээш хувийн саналаар зарлаж хуралдуулж болно.

5.3. Салбар хорооны хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох байгууллагын төлөөлөл, мэргэжилтэн шинжээчдийг оролцуулж болно.

5.4. Салбар хорооны хурлаас гарах шийдвэрийг гишүүд зөвшилцэн батлах бөгөөд тэмдэглэл хөтөлнө.

5.5. Салбар хорооны хурлын шийдвэрийг тэмдэглэл, тогтоол хэлбэрээр гаргана. Хурлын шийдвэрт салбар хорооны дарга гарын үсэг зурж, тэмдэг дарснаар баталгаажна.

\_\_\_\_oOo\_\_\_\_